

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
3.1 Бараа материалын данстай холбоотой асуудал	9
3.2 Үндсэн хөрөнгө данстай холбоотой асуудал	9
3.3 Шатахууны зардалтай холбоотой асуудал.....	10
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БСШУСЯ	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
САГ	Санхүүгийн аудитын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШУА	Шинжлэх ухааны академи



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХИМИ, ХИМИЙН ТЕХНОЛОГИЙН
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ
Л.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

2020.08.21 № 06/567
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, 18.5 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус хүрээлэнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Л.Жаргалсайхан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн бараа материалын тайланг үнэн зөв гаргаж байх, үндсэн хөрөнгө, шатахууны зардал, цалин хөлсийг үнэн зөв тооцож байх, холбогдох хууль журам зааврыг мөрдөж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 31-нээс 2020 оны 02 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Голден пэйж Аудит ХХК-ийн захирал С.Оюунгэрэл хянан удирдаж, аудитор Ц.Долгормаа, аудиторовын туслах Г.Ариунтуяа, Г.Ариун-Эрдэнэ нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01/34 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хими, химийн технологийн хүрээлэнгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь: Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн химийн аж үйлдвэрийг хөгжүүлэх шинжлэх ухааны үндэслэлийг бий болгох, химийн шинжлэх ухааныг шинэ мэдлэг мэдээллээр баяжуулахад оршино.

Хими, химийн технологийн хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэл:

- Эх орны эрдэс түүхий эдийг баяжуулах, боловсруулах байгаль орчинд ээлтэй дэвшилтэд технологийн судалгаа хийх
- Нүүрс газрын тос боловсруулах байгаль орчинд ээлтэй технологийн судалгаа хийх
- Эх орны амьтан ургамал, микробын гаралтай түүхий эдийг иж бүрэн боловсруулах, энэ чиглэлийн бодис бүтээгдэхүүн гарган авах, бүтэц байгууламж шинж чанарыг тогтоох, энэ чиглэлийн үйлдвэрлэлийн технологи, дизайныг хөгжүүлэх онолын болон хавсарга судалгаа явуулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлд “нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ”
- Хөдөлмөрийн тухай хуулийн 76 дугаар зүйлд “нийтээр амрах баярын өдөр”
- ХХОАТ-ын тухай хуулийн 24 дүгээр зүйлд “албан татварын хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлэх” гэсэн заалтуудад тус тус өөрчлөлт орсон байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус хүрээлэнгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хими, химийн технологийн хүрээлэн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Accolous программ хангамж ашиглаж байна.

Хими, химийн технологийн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хими, химийн технологийн хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 28 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн үр

дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,824,737.1 мянган төгрөгөөс тооцон 28,274.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 28,274.4 мянган төгрөгөөр тооцлоо.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,913,951.9 мянган төгрөгөөр буюу 56.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	120,708.90	380,306.40	259,597.50
Урьдчилгаа	-	146,000.00	146,000.00
Бараа материал	109,043.70	88,598.50	(20,445.20)
Үндсэн хөрөнгө	7,130,008.20	9,593,789.90	2,463,781.70
Үндсэн хөрөнгийн элэгдэл	(2,162,405.60)	(2,097,387.80)	65,017.80
Нийт хөрөнгө	5,197,355.20	8,111,307.10	2,913,951.90
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,197,355.20	8,111,307.10	2,913,951.90
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,197,355.20	8,111,307.10	2,913,951.90

Авлага дансны үлдэгдэл 259,597.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь татаас санхүүжилтийн авлагатай холбоотой. Дээрх авлагыг 2019 оны жилийн эцсийн тайлангаар бүрэн тооцоо нийлж баталгаажуулсан.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 146,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Байгаль орчны яамны агаарын бохирдлыг бууруулах хорооноос хийн багаж худалдан авах санхүүжилт 292,000.0 мянган төгрөг орж ирснээс 50.0 хувийн эрхийг нээж бэлтгэн нийлүүлэгчийн дансанд төвлөрүүлсэн дүн болно.

Бараа материалын дансны үлдэгдэл 20,445.0 мянган төгрөгөөр буурсан нь зарцуулалтаас шалтгаалсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,528,799.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 121,388.1 мянган төгрөгийн, өөрийн хөрөнгөөр 114,058.4 мянган төгрөгийн хөрөнгө тус тус худалдаж авсан. Улсын комиссын 2018/145 тоот актын дагуу 2,252,900.0 мянган төгрөгийн барилга ашиглалтанд оруулсан. Байгаль орчны яамнаас балансаас балансад ТӨБЗГ-ын зөвшөөрлийн дагуу 398,608.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлэн авч, ТӨБЗГ-ын 2019 оны 298, 519, 536 тоот тогтоолын дагуу акталж устгасан 423,172.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хассантай холбоотой.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрт зориулан 1,902,154.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,794,154.5 мянган төгрөгийг урсгал зардалд, 108,000.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардлын төсөв батлагджээ.

Нийт зардлын 1,902,154.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 16,600.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Урсгал зардлын гүйцэтгэлд 1,918,754.5 мянган төгрөг зарцуулах төсөв батлагдсанаас 1,918,053.9 мянган төгрөг зарцуулж, 646.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагч БСШУСЯ-аас 452,727.0 мянган төгрөг, бусад эх үүсвэрээс 834,426.1 мянган төгрөгөөр санхүүжүүлж, 2,639.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 28 эрсдэл тодорхойлж нийт 28 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн нийт 8,880.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, Менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Үндсэн хөрөнгө дансыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хими, химийн технологийн хүрээлэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 106 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Шинээр ажилд орсон нягтлан бодогчийн нэр, холбоо барих утасны дугаарыг шинэчлээгүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 19,034.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 70.0 хувьтай байна. Үүнд: Тендер зарлахгүйгээр бараа ажил, үйлчилгээ авсан, 1 тракторыг 2 үнээр салгаж бүртгэсэн гэх 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, хөрөнгөнд тавих хяналтыг сайжруул гэсэн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Бараа материалын данстай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт: Бараа материалын дэлгэрэнгүй тайлангуудыг сар бүр хэвлэн авч, гарын үсэг тамга тэмдгээр баталгаажуулан архивлаагүй, шатах тослох материалын үлдэгдэл 217.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 “анхан шатны баримтыг үндэслэн дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, ажил гүйлгээний мэдээ гаргах, үнэн зөв хураангуйлан дансанд бүртгэх” гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2. Эрсдэл: Холбогдох хууль тогтоомж, тушаал шийдвэр хэрэгжихгүй байх;

3.1.3. Өгсөн зөвлөмж: Бараа материалын тайланг сар бүр хэвлэн авч, гарын үсэг тамга тэмдгээр баталгаажуулан архивладаг байх;

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Тайлант хугацаанаас өмнө байсан үлдэгдлийн зарцуулалтыг холбогдох хуулийн зүйл заалтад зохицуулан удирдлагын шийдвэр гаргаж тодорхой арга хэмжээг 2020 оны эхний хагас жилийн тайланд тусгах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.2 Үндсэн хөрөнгө данстай холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт:

- Үндсэн хөрөнгийн тооллогын ажиглалтаар үндсэн хөрөнгийг кодолж бүртгэлжүүлээгүй, түүвэр тооллогоор сонгогдсон тээврийн хэрэгсэл болох Sonata 6 маркийн машин нь 1,000.0 мянган төгрөгөөр бүртгэлтэй;
- ТӨБЗГ-ын 2019.10.29-ний өдрийн 432 тоот Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай албан бичгээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас шилжиж ирсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлж, ашиглалтын хугацааг шинээр тогтоогоогүй;
- Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Weifang маркийн Трактор нь Баялаг эрдэнэ ХХК-ийн эзэмшилд бүртгэлтэй. (Үйлдвэрлэсэн 1998 он 2012 онд Монголд орж ирсэн) байгаа нь УСНББОУС 17, аудитын Үнэлгээ: “Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг тайлант хугацаанд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимтай нийцүүлэн зөв үнээр бүртгэсэн байх”, Эрх ба үүрэг: “Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө/... тухайн

байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй,... үүрэгтэй байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- 3.2.2 Эрсдэл: УСНББОУС, холбогдох хууль тогтоомж, тушаал шийдвэр, аудитын батламж мэдэгдлүүд хэрэгжихгүй байх;
- 3.2.3 Өгсөн зөвлөмж: УСНББОУС 17, Үнэлгээ: “Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг тайлант хугацаанд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимтай нийцүүлэн зөв үнээр бүртгэсэн байх” гэсэн батламж мэдэгдлийг мөрдөн ажиллах;
- 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: УСНББОУС 17 дагуу хөрөнгүүдэд нарийвчилсан үнэлгээ хийх ажлыг 2020 оны 2-р улиралд багтаан хийхээр төлөвлөн ажиллаж байгаа

3.3 Шатахууны зардалтай холбоотой асуудал

- 3.3.1 Илрүүлэлт: Санхүүгийн тайлангаар 14,575.0 мянган төгрөгийн шатахууны зардал тайлагнасан. Үүнээс 2,745.0 мянган төгрөгийн шатахуун нь байгууллагын үйл ажиллагаанд, зарцуулагдсан ч дэмжих баримтыг мөнгөн дүнгээр илэрхийлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.
- 3.3.2 Эрсдэл: Холбогдох хууль тогтоомж, тушаал шийдвэр хэрэгжихгүй байх;
- 3.3.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 заалтыг хэрэгжүүлэх;
- 3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрч байна. 2020 онд энэ төрлийн алдаа гаргахгүй ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>229,752,611.20</u>	<u>614,904,886.51</u>
33	АВЛАГА	120,708,942.49	380,306,372.11
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	322,809.00	76,886.22
33300	Татаас, санхүүжилтийн авлага	118,532,076.20	380,229,485.89
335	Бусад авлага	1,854,057.29	-
3351	Байгууллагаас авах авлага	1,854,057.29	-
34	УРЬДЧИЛГАА	-	146,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	109,043,668.71	88,598,514.40
351	Түүхий эд материал	12,099,787.36	11,904,461.96
35110	Тусгай зориулалттай материал	12,099,787.36	11,904,461.96
35300	Бэлэн бүтээгдэхүүн	15,403,000.00	704,770.00
354	Хангамжийн материал	81,540,881.35	75,989,282.44
35410	Бичиг хэргийн материал	3,112,137.00	4,536,399.00
35420	Аж ахуйн материал	13,027,397.00	16,126,197.00
35430	Сэлбэг хэрэгсэл	44,281,842.00	42,583,870.00
35440	Түлш, шатах тослох материал	217,000.00	217,000.00
35470	Бусад хангамжийн материал	20,902,505.35	12,525,816.44
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,967,602,607.76</u>	<u>7,496,402,209.22</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,967,602,607.76	7,496,402,209.22
392	Биет хөрөнгө	4,761,463,938.63	7,304,471,391.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,730,009,418.00	5,982,909,418.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(163,314,725.76)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,913,000.00	15,913,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(31,496,333.38)	(15,663,000.06)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,743,555,079.97	3,024,253,693.81
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,999,580,567.47)	(1,816,005,538.57)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	403,619,045.25	353,109,063.16
39208	Хуримтлагдсан элэгдэл	(126,674,351.73)	(6,449,766.65)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,900,000.00	2,900,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,480,208.17)	(1,842,708.13)
39217	Ном	8,698,856.16	8,661,956.16
393	Биет бус хөрөнгө	206,138,669.13	191,930,817.26
39301	Програм хангамж	3,820,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,174,170.87)	(412,500.06)
39303	Бусад биет бус хөрөнгө	205,492,840.00	205,492,840.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(13,699,522.68)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,197,355,218.96</u>	<u>8,111,307,095.73</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,197,355,218.96</u>	<u>8,111,307,095.73</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,197,355,218.96	8,111,307,095.73
511	Засгийн газрын оруулсан капитал, орон нутгийн сан	3,282,597,658.51	3,282,597,658.51

51101	Өмч: - төрийн	3,282,597,658.51	3,282,597,658.51
512	Хуримтлагдсан үр дүн	(1,151,973,887.57)	1,827,762,148.77
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,151,973,887.57)	(1,086,330,061.00)
51220	Тайлант үеийн үр дүн	-	2,914,092,209.77
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,066,731,448.02	3,000,947,288.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5,197,355,218.96</u>	<u>8,111,307,095.73</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,045,634,815.90	5,738,829,341.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	629,792,662.40	2,668,053,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	629,792,662.40	2,668,053,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	626,835,862.40	2,663,349,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,707,700.00	11,841,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	612,128,162.40	2,651,508,000.00
120005	Түрээсийн орлого	2,956,800.00	4,704,000.00
120009	Бусад орлого	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,415,842,153.50	3,070,775,441.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,627,218,700.00	1,902,154,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,627,218,700.00	1,902,154,500.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	787,593,762.00	1,168,620,941.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	375,156,562.00	296,555,041.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	408,721,500.00	452,727,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,715,700.00	419,338,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,029,691.50	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,029,691.50	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,393,462,127.23	2,820,413,450.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,393,462,127.23	2,820,413,450.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,364,087,296.49	2,802,175,682.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,254,439,420.06	1,467,540,345.08
210101	Үндсэн цалин	1,055,887,809.17	1,197,803,594.08
210102	Нэмэгдэл	154,719,983.40	194,806,451.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	37,030,278.49	74,930,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	148,194,657.52	185,139,971.11
210201	Тэтгэврийн даатгал	103,762,357.71	130,353,354.11
210202	Тэтгэмжийн даатгал	12,255,583.00	14,283,364.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,372,369.67	11,321,731.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,217,527.49	2,641,954.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,586,819.65	26,539,568.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,212,289.89	88,646,438.76
210301	Гэрэл, цахилгаан	25,903,090.00	25,749,026.00
210302	Түлш, халаалт	44,682,679.00	49,332,268.41
210303	Цэвэр, бохир ус	13,626,520.89	13,565,144.35
2104	Хангамж, бараа материалын зардал	41,456,270.33	112,855,304.13
210401	Бичиг хэрэг	12,663,775.00	12,995,642.00
210402	Тээвэр, шатахуун	3,498,000.00	14,575,000.00

210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	1,880,816.33	1,702,037.22
210404	Ном, хэвлэл	230,100.00	2,434,797.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,940,000.00	2,040,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,243,579.00	79,107,827.91
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	-
2105	Нормативт зардал	2,070,730.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,070,730.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	85,895,009.01	104,684,326.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	60,000.00	231,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		15,382,000.00
210604	Урсгал засвар	85,835,009.01	89,071,326.00
2107	Томилолт, зочны зардал	3,368,140.00	18,295,400.00
210701	Гадаад албан томилолт	2,405,900.00	5,300,000.00
210702	Дотоод албан томилолт	962,240.00	12,995,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	394,480,031.99	332,270,710.51
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	391,543,899.99	328,444,600.51
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	71,280.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,100.00	70,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
210807	Газрын төлбөр	866,032.00	1,662,730.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	349,970,747.69	492,743,186.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,322,948.20	118,563,465.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	189,853,715.00	20,348,529.18
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	140,794,084.49	353,831,192.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,374,830.74	18,237,767.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,897,204.00	14,951,900.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,273,968.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,623,236.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	14,951,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	3,285,867.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		3,285,867.90
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,477,626.74	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,477,626.74	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	652,172,688.67	2,918,415,890.61
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	24,755,595.00	4,323,680.84
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	4,323,680.84
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	24,755,595.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(24,755,595.00)	(4,323,680.84)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	627,417,093.67	2,914,092,209.77

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,564,417,941.00</u>	<u>3,205,853,417.20</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,664,500.00	16,545,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	17,664,500.00	16,545,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,707,700.00	11,841,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,707,700.00	11,841,900.00
120005	Түрээсийн орлого	2,956,800.00	4,704,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,546,753,441.00	3,189,307,517.20
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,627,218,700.00	1,902,154,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,627,218,700.00	1,627,218,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	919,534,741.00	1,287,153,017.20
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	506,919,541.00	415,087,117.20
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	408,721,500.00	452,727,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,893,700.00	419,338,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,370,772,187.80</u>	<u>2,970,406,942.58</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,370,772,187.80	2,970,406,942.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,222,865,280.86	2,571,939,688.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,254,762,229.06	1,469,269,477.56
210101	Үндсэн цалин	1,057,327,459.06	1,218,085,772.56
210102	Нэмэгдэл	154,173,779.00	205,881,305.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	37,030,737.00	45,302,400.00
210104	Урамшуулал	6,230,254.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,011,779.11	182,337,774.56
210201	Тэтгэврийн даатгал	127,269,654.82	127,539,308.56
210202	Тэтгэмжийн даатгал	5,835,155.00	14,106,466.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,330,041.29	10,851,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,047,644.00	2,712,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,529,284.00	27,128,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,212,289.89	88,646,438.76
210301	Гэрэл, цахилгаан	25,903,090.00	25,749,026.00
210302	Түлш, халаалт	44,682,679.00	49,332,268.41
210303	Цэвэр, бохир ус	13,626,520.89	13,565,144.35
2104	Хангамж, бараа материалын зардал	40,668,241.33	50,195,916.22
210401	Бичиг хэрэг	1,105,750.00	1,918,147.00
210402	Тээвэр, шатахуун	3,498,000.00	2,750,000.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	1,880,816.33	1,713,027.22
210404	Ном, хэвлэл	20,720,100.00	8,751,050.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,801,400.00	2,040,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,662,175.00	33,023,692.00
2105	Нормативт зардал	1,800,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,800,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	73,241,140.00	219,318,176.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	185,400.00	161,401,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		15,382,000.00
210604	Урсгал засвар	73,055,740.00	42,534,676.00
2107	Томилолт, зочны зардал	962,240.00	25,545,400.00
210701	Гадаад албан томилолт		5,300,000.00
210702	Дотоод албан томилолт	962,240.00	20,245,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	426,689,583.47	508,765,246.51
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	423,753,451.47	504,939,136.51
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	71,280.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,100.00	70,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
210807	Газрын төлбөр	866,032.00	1,662,730.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	191,517,778.00	27,861,259.18
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	191,517,778.00	27,861,259.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	147,906,906.94	398,467,253.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,897,204.00	14,951,900.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,273,968.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,623,236.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	14,951,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	383,515,353.79
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	383,515,353.79
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	126,009,702.94	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	126,009,702.94	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>193,645,753.20</u>	<u>235,446,474.62</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	193,645,753.20	235,446,474.62
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	193,645,753.20	235,446,474.62
2200	Дотоод эх үүсвэрээр	193,645,753.20	235,446,474.62
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	193,645,753.20	235,446,474.62
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(193,645,753.20)</u>	<u>(235,446,474.62)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,077,104,818.51	812,931,730.57	-1,779,390,981.24	2,110,645,567.84
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,077,104,818.51	812,931,730.57	-1,779,390,981.24	2,110,645,567.84
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	2,253,799,717.45	-	2,253,799,717.45
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	205,492,840.00	-	-	205,492,840.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	627,417,093.67	627,417,093.67
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,282,597,658.51	3,066,731,448.02	-1,151,973,887.57	5,197,355,218.96
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	65,643,826.57	65,643,826.57
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,282,597,658.51	3,066,731,448.02	-1,086,330,061.00	5,262,999,045.53
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-65,784,159.57	-	-65,784,159.57
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	2,914,092,209.77	2,914,092,209.77
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,282,597,658.51	3,000,947,288.45	1,827,762,148.77	8,111,307,095.73

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,918,754,500.00	1,918,053,932.10	700,567.90	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,918,754,500.00	1,918,053,932.10	700,567.90	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,912,404,500.00	1,911,703,932.10	700,567.90	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,412,220,500.00	1,412,174,304.56	46,195.44	100.0
210101	Үндсэн цалин	1,160,990,600.00	1,160,990,599.56	0.44	100.0
210102	Нэмэгдэл	205,927,500.00	205,881,305.00	46,195.00	99.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,302,400.00	45,302,400.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	176,056,100.00	175,469,937.56	586,162.44	99.6
210201	Тэтгэврийн даатгал	121,800,100.00	120,671,471.56	1,128,628.44	99.0
210202	Тэтгэмжийн даатгал	13,564,000.00	14,106,466.00	(542,466.00)	104.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,851,200.00	10,851,200.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,712,800.00	2,712,800.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	27,128,000.00	27,128,000.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,648,900.00	88,646,438.76	2,461.24	100.0
210301	Гэрэл, цахилгаан	27,198,700.00	25,749,026.00	1,449,674.00	94.6
210302	Түлш, халаалт	48,064,200.00	49,332,268.41	(1,268,068.41)	102.6
210303	Цэвэр, бохир ус	13,386,000.00	13,565,144.35	(179,144.35)	101.3
2104	Хангамж, бараа материалын зардал	14,617,000.00	12,848,611.22	1,768,388.78	87.9
210401	Бичиг хэрэг	2,880,000.00	1,918,147.00	961,853.00	66.6
210402	Тээвэр, шатахуун	2,160,000.00	2,160,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	2,700,000.00	1,713,027.22	986,972.78	63.4
210404	Ном, хэвлэл	407,000.00	609,150.00	(202,150.00)	149.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,810,000.00	1,810,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,660,000.00	4,638,287.00	21,713.00	99.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	137,782,000.00	137,746,030.00	35,970.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	108,000,000.00	108,000,000.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	15,382,000.00	15,382,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	14,400,000.00	14,364,030.00	35,970.00	99.7

2107	Томилолт, зочны зардал	200,000.00	90,000.00	110,000.00	45.0
210702	Дотоод албан томилолт	200,000.00	90,000.00	110,000.00	45.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	82,880,000.00	84,728,610.00	(1,848,610.00)	102.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	78,910,000.00	80,902,500.00	(1,992,500.00)	102.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	71,280.00	128,720.00	35.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	70,100.00	9,900.00	87.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	1,668,000.00	1,662,730.00	5,270.00	99.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,350,000.00	6,350,000.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,350,000.00	6,350,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,350,000.00	6,350,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,918,754,500.00	1,918,053,932.10	700,567.90	99.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,902,154,500.00	1,901,508,032.10	646,467.90	99.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,902,154,500.00	1,901,508,032.10	646,467.90	99.9
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	16,600,000.00	16,545,900.00	54,100.00	99.6
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,918,754,500.00	1,918,053,932.10	700,567.90	99.9

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		904,284,131.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ		904,284,131.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		895,682,231.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		57,095,173.00
210101	Үндсэн цалин		57,095,173.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		6,867,837.00
210201	Тэтгэврийн даатгал		6,867,837.00
2104	Хангамж, бараа материалын зардал		37,510,405.00
210402	Тээвэр, шатахуун		590,000.00
210404	Ном, хэвлэл		8,305,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		230,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		28,385,405.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		213,391,346.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		177,315,500.00
210602	Тавилга		7,905,200.00
210604	Урсгал засвар		28,170,646.00
2107	Томилолт, зочны зардал		25,455,400.00
210701	Гадаад албан томилолт		5,300,000.00
210702	Дотоод албан томилолт		20,155,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		527,500,811.13
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		527,500,811.13
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		27,861,259.18
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		27,861,259.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		8,601,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		8,601,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		8,601,900.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		904,284,131.31
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		904,284,131.31
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		70,123,974.69
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		420,198,456.62
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		413,961,700.00

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.02.17	Аудитын нэр: Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн	Аудитын код: САГ-2020/55/СТА-
Шалгагдсан байгууллагын нэр: ШУА-ийн Хими, Химийн технологийн хүрээлэн	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Бараа материал	217.0	Аудитын зөвлөмж	Дарга, Ахлах нягтлан бодогч	Л.Жаргалсайхан, Б.Нэргүй
2	Үндсэн хөрөнгө	5,913.9	Аудитын зөвлөмж	Дарга, Ахлах нягтлан бодогч	Л.Жаргалсайхан, Б.Нэргүй
3	Шатахууны зардал	2,750.0	Аудитын зөвлөмж	Дарга, Ахлах нягтлан бодогч	Л.Жаргалсайхан, Б.Нэргүй
	Дүн	8,880.6			

